**МОНГОЛ УЛС**
**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2021 оны 06 сарын 16 өдөр Дугаар А/215 Мандалговь

Өмчлөлийн газраа өвлөн авах тухай

"Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль"–ийн 5.1.4 дэх заалт, 27 дугаар зүйлийн 27.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өмчлөлийн газраа өвлөн авах тухай хүсэлт гаргасан иргэдийн хүсэлт, ITRF-97 солбицолын тогтолцоонд хийгдсэн кадастрын зургийг UTM тусгагт хөрвүүлэхэд систем хоорондын зөрүүнээс үүдэж эдлэн газрын кадастрын зургийн талбайн хэмжээ зөрүүтэй гарч байгаа 1 нэгж талбарын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Кадастрын зургийн талбайн хэмжээ, хаягийн өөрчлөлтийг аливаа шилжилт хөдөлгөөн хийлгэхээр газар өмчлөгч хүсэлт гаргасан тухай бүр шийдвэрлүүлж газрын улсын бүртгэлд өөрчлөлт оруулах иргэд олон нийтэд мэдээлэл өгч ажиллахыг Сайнцагаан сумын Засаг дарга (С.Бат-Оргил), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Газрын талбайн хэмжээ болон хаягийн өөрчлөлтийг тухай бүр гарсан шийдвэрийг үндэслэн газар өмчлөгч иргэдэд хүндрэл, чирэгдэлгүй, хууль тогтоомжид заасны дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Улсын бүртгэл хэлтэс (Б.Сайхантуяа)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2006 оны 366 дугаар захирамжийн хавсралтын 3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ

481210576

Дундговь аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн А/315 дугаар захирамжийн хавсралт

| № | Газар өвлөгчийн | | | Өмнөх захирамжийн | | Өмнөх газрын | | Газрын | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Овог | Нэр | Регистрийн дугаар | Огноо дугаар | Холбогдох хэсгийн дугаар | Нэгж талбарын дугаар | Хэмжээ /м2/ | Хэмжээ /м2/ | Байршил | Үнэ /төгрөг/ |
| 1 | Шатар | Отгонсүрэн | ЗК76080306 | 2006 №366 | 3 | 1111000817 | 520 | 578 | Мандал 12-1200 | 1156000 |
| 2 | Далх | Дэжид | ЗК38052109 | | | | | | | |
| 3 | Охиноо | Удвал | ЗК95112107 | | | | | | | |